

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Сайн Байцгаана уу,

Та бүхэн хаврын амралтаа сайхан өнгөрүүлсэн гэдэгт бид итгэлтэй байна. Бид энэ хичээлийн жилийн сүүлчийн улирал буюу 4-р улирлын хичээлээ эхлээд байна. Дунд сургуулийн сурагчид жүжигчилсэн тоглолтондоо бэлтгэж, бага сургуулийн сурагчид өнөөдөр өдөрлөг зохион байгуулж төгсөх ангийн сурагчид маань дипломын шалгалтандаа бэлдэцгээж байна.

2 долоо хоногийн өмнө удирдах зөвлөлийн гишүүд, багш нар, сурагчид, эцэг эхчүүд стратеги төлөвлөгөөний сургалтанд оролцож 2 өдрийн туршид ажилласан. Ирэх хэдэн долоо хоногийн хугацаанд бид жижиг бүлгүүдэд хуваагдаж ажиллах болно. Та бүхэн хэгийн төлөвлөгөө боловсруулах энэ ажилд оролцох хүсэлтэй бол удирдах зөвлөлийн дарга [Shane Rosental](mailto:shane.rosenthal@gmail.com)-тай [shane.rosenthal@gmail.com](mailto:shane.rosenthal@gmail.com) хаягаар холбоо барина уу.

Багш сонгон шалгаруулж авах ажил амжилттай явагдаж байна. Бид одоо хоёр орон тоон дээр багш шалгаруулж авна. Дунд сургуулийн математик, бага сургуулийн англи хэлний багш нарыг шинээр ажилд авна. Ирэх хичээлийн жилд хэд хэдэн шинэ багш нар ОУДС-д ирж ажиллах болсоныг та бүхэнд дуулгахад таатай байна. 2010-2012 оны хичээлийн жилд ОУДС-д шинээр ирж ажиллах мэргэжлийн дуу хөгжмийн багш, мэргэжлийн номын санч ажилд авсан бөгөөд бусад багш нарын талаарх мэдээллийг би та бүхэнд удахгүй хүргэх болно.

Бид удахгүй ирэх хичээлийн жилийн элсэлтийн талаарх захидлыг та бүхэнд илгээж та бүхний хариут хүлээх болно.

Та бүхэнтэй сургууль дээр удахгүй уулзана гэж найдаж байна.

**Захирал Greg Rayl**

### **ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:**

4 сарын 17-ны Бямба гараг	Сургуулийн цэвэрлэгээ 9:00-13:00
4 сарын 18-ны Ням гараг	Усны Төлөө Гүйцгээе (10:00-10:45)
4 сарын 20	4-р улирлын Дугуйлангууд эхэлнэ
5 сарын 1	Дунд Сургуулийн сурагчдын жүжигчилсэн тоглолт (Тоглолтын өдөр өөрчлөгдсөнийг анхаарна уу)
5 сарын 21	Урлагийн авъяастнуудын өдөр

## **Хаврын Жүжигчилсэн Тоглолт “Mother Dear”**

**2010 оны 5 сарын 1-ны Бямба Гарагт**

**Хаан Банкны Театрт**

**Өдрийн Тоглолт: 15:00-17:00**

**Оройн Тоглолт: 19:00-21:00**

**Билетийн Үнэ: 3000 Төгрөг**

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Цаг агаар дулаарч байгаа энэ долоо хоногт бид 4-р улирлын хичээлээ эхэлж Усны Төлөө Гүйцгээе арга хэмжээнд бэлтгэж завгүй ажиллацгааж байна. 10-р ангийн сурагчид маань Усны Төлөө Гүйцгээе арга хэмжээг анх удаагаа санаачлан энэ 4 сарын 18-ны Ням гарагт зохион байгуулах гэж байна. Та бүхэн энэ арга хэмжээг дэмжиж оролцон усны төлөө гүйгээрэй. Энэ арга хэмжээг төлөвлөж зохион байгуулах явцдаа 10-р ангийн сурагчид маань өөрсдөө их зүйлд суралцаж байгаа бөгөөд энэ арга хэмжээ олныг хамарсан томоохон үйл явдал болно.

Энэхүү арга хэмжээг амжилттай зохион байгуулахад бэлтгэл ажил, хүн бүрийн чармайлт, оролцоо, туйлын чухал бөгөөд усны төлөө гүйх нь биднийг нэгтгэж байгаа учраас та бүхэн хүрэлцэн ирж

манай хүүхдүүдийг дэмжиж энэ арга хэмжээнд идэвхтэй оролцоорой. Мөн монгол хүүхдүүд ундны усаа хэрхэн авдаг талаар сонирхолтой кино хийгдэх болно. Та бүхнийг усны төлөө гүйхийг урьж байна.

4 сарын 22-ны үдээс хойш бид Эцэг Эхийн хурал хийнэ. Хүүхдийнхээ сурлагын дүнтэй хамт та бүхэн хуралд ирэх захидлыг хүлээн авсан бол цаг гаргаж заавал энэ хуралд оролцоорой.

Дугуйлангууд ирэх долоо хоногоос эхэлж хичээллэнэ. Хөвгүүдийн хөл бөмбөгийн дугуйлан Даваа гарагт хичээллэхгүй. 4 сарын 19-нд дасгалжуулагч ирэх боломжгүй болсон тул хүлцэл өчье.

Та бүхэн сургууль дээр хүрэлцэн ирж сурагчдын зурсан бүтээлүүдийг сонирхож, манай номын сангаар зочилж сурагчдын хичээл сурлагын байдалтай танилцаарай. Бид багш сурагчдаараа байнга бахархаж байдаг бөгөөд энэ бүхнийгээ та нартай хуваалцахыг хүсдэг.

Сурагчдын удирдсан хуралд хүрэлцэн ирсэн бүх эцэг эхчүүддээ баярлалаа. Энэ хуралд дунд сургуулийн нийт эцэг эхчүүдийн 99% нь ирж оролцсонд бид их баяртай байна.

**Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann**

### **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

4-р улирлын хичээл эхэллээ. Та бүхэн хаврын амралтаар хүүхдүүдтэйгээ сайхан амарсан гэдэгт бид итгэлтэй байна. Бага Сургуулийн багш нар Даваа гарагт Тооны болон Хэлний хичээлийн хөтөлбөрүүд дээр ажиллалаа.

**Усны Төлөө Гүйцгээе:** Ням гарагт болох Усны Төлөө Гүйцгээе арга хэмжээнд манай бага сургуулийн эцэг эхчүүд олноороо оролцоно гэдэгт бид итгэлтэй байна. Хэрвээ та бүхэн бүртгүүлж амжаагүй бол бүтэн сайны өглөө 10:00-10:45-н хооронд бүртгүүлэх боломжтой. Гүйлт 11 цагаас эхэлнэ.

**2-р ангийн сурагчдын Хүсэлт:** “Sharing the Planet” сэдвийн хүрээнд 2-р ангийн сурагчид хальсан уут цуглуулж байгаа тул та бүхэн 2-р ангийг ханд хальсан уутнууд авчирч өгөөрэй.

“Charlie and The Chocolate Factory” DVD-ний захиалгаа авч дууссан бөгөөд DVD бидний гар дээр удахгүй ирнэ. Хэрвээ та бүхэн Chris De Nogales-н авсан зурагнуудыг худалдаж авах хүсэлтэй бол 4 сарын 22-ны Пүрэв гаргаас өмнө захиалгаа таарсан мөнгөтэй нь ирүүлээрэй. Хоцорсон захиалган дээр нэмж 2000 төгрөг төлнө. Зураг болон зургийн кодыг [www.flickr.com/photos/denogalesphoto](http://www.flickr.com/photos/denogalesphoto) хаягаар орж харах боломжтой. 13x18 cm=700 төгрөг; 16x22cm=1500 төгрөг

**Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins**

Бага Сургуулийн 4-р ангийг эрчим хүчний талаарх сэдвийг судалж эхэлсэн бөгөөд бид энэ чиглэлээр аялал зохион байгуулж зочин урьж ярилцах хүсэлтэй байна.

Хэрвээ та бүхэн эрчим хүчний чиглэлээр бизнес эрхэлдэг бөгөөд дулааны цахилгаан станц болон уурхай дээр аялал хийхэд бидэнд туслах, эсвэл сургууль дээр хүрэлцэн ирж нарны, усны, цөмийн эрчим хүчний талаар бидэнтэй ярилцах боломжтой бол Mrs. D’Souza болон Ms. Faber нартай дараах e-мэйл хаягаар холбоо барина уу:

[s.dsouza@isumongolia.edu.mn](mailto:s.dsouza@isumongolia.edu.mn)

[m.faber@isumongolia.edu.mn](mailto:m.faber@isumongolia.edu.mn)

### **ОУХНН (Монгол дахь Олон Улсын Хатагтай Нарын Нийгэмлэг) – т зориулсан хандив**

Хаврын амралтаар гадагшаа явахдаа цуглуулж ирсэн ариун цэврийн жижиг зүйлсийг хандивласан та бүхэнд баярлалаа. Даваа гарагт та бүхэн бидний хандивын хайрцагт хийх ариун цэврийн жижиг зүйлс байвал авчирч болно. ОУХНН-ийн төлөөлөгч бидний цуглуулсан хандивыг хэрэгцээтэй хүмүүст нь тарааж өгөх болно. Бие угаах жижиг алчуур болон авиа компаниудаас өгдөг ууттай оймсыг бид бас хандивт авч байгаа.

## **БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС**

### **Бямба Гарагийн Цэвэрлэгээ**

4 сарын 17-ны Бямба гарагт ОУДС Бямба гарагийн цэвэрлэгээ хийж хөл бөмбөгийн талбайн хогийг цэвэрлэж ургасан зэрлэгийг түүнэ. Сурагчид завсарлагаанаар болон биеийн тамирын хичээлийн үеэр тэгш, цэвэр талбай дээр хөл бөмбөг тоглох боломжтой болно. Дунд сургуулийн сурагчид болон эцэг эхчүүдийг энэ арга хэмжээнд сайн дураараа оролцохыг бид бүхэн уриалж байна. Сурагчдын ажилласан цагийг CAS-н цагт тооцох болно.

Бид цэвэрлэгээг 9 цагт эхэлж олон сурагчид, эцэг эхчүүдийн тусламжтайгаар 1 цаг гэхэд талбайг цэвэрлэж дуусгана. Сургууль цэвэрлэгээний материалыг хангаж өгнө. Хүсвэл эцэг эхчүүд, сурагчид та бүхэн өөрсдийн багажаа авчирч болно. Цэвэрлэх талбайг шүүрдэхээс өмнө тоос босгохгүйн тулд услах болно. Сургууль салхины шил, амны хаалт тарааж өгнө. Сурагчид өөрсдийн шил, амны хаалгаа авчирч хэрэглэж болно.

Цэвэрлэгээний туршид уух ус, снак авах боломжтой. Цэвэрлэгээ дууссаны дараа хөл бөмбөг тоглох боломжтой.